



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/369

Бсөлбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлт"-ийн бодлогыг хэрэгжүүлэх зорилт болон "Боомтын сэргэлт", "Бүсчилсэн хөгжлийн бодлого"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Нарансэвстэй-Мазушань" боомтыг нээх ажиллуулах чиглэлээр судалгаа хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн ажиллах, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганьсу муж, Жьочуань хот, Сүбэй хошууны удирдлагуудтай хийх уулзалт зохион байгуулах арга хэмжээнд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 16,478,300 (арван зургаан сая дөрвөн зуун далан найм мянга гурван зуу) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

